### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүрэээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,247,073.22 мянган төгрөгөөр буюу 51 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

/мянган төгрөг/

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 878,287.27 | 1,374,132.47 | 495,845.20 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 245,342.68 | 633,535.81 | 388,193.13 |
| 33 | АВЛАГА | 400,813.41 | 333,376.58 | -67,436.82 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 105,510.07 | 153,697.53 | 48,187.46 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,557,113.54 | 2,308,341.56 | 751,228.02 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,557,113.54 | 2,308,341.56 | 751,228.02 |
| | Хуримтлагдсан элэгдэл | -974,661.20 | -1,105,972.89 | -131,311.69 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,435,400.81 | 3,682,474.03 | 1,247,073.22 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 16,237.45 | 69,182.13 | 52,944.68 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,419,163.36 | 3,613,291.90 | 1,194,128.53 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,419,163.36 | 3,613,291.90 | 1,194,128.53 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,435,400.81 | 3,682,474.03 | 1,247,073.22 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 633,535.8 мянган төгрөг болж өмнөх оноос 388,193.1 мянган төгрөгөөр *өссөн* байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө | 245,342.7 | 633,535.8 | 388,193.1 | 158.2 |
| **Дүн** | **245,342.7** | **633,535.8** | **388,193.1** | **158.2** |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 633,535.8 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 406,617.0 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 190,565.9 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 36,352.9 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 333,376.5 мянган төгрөг болж өмнөх оноос 67,436.9 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл*

/ мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон авлага | 0 | 46.5 | 46.5 |
| Татаас санхүүжилтын авлага | 90,000.0 | - | (90,000.0) |
| Байгууллагаас авах авлага | 3,066.9 | - | (3,066.9) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 97,892.7 | 115,699.3 | 17,806.6 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 75,483.5 | 100,116.3 | 24,632.8 |
| Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл | 134,370.3 | 117,514.4 | (16,855.9) |
| **Дүн** | **400,813.4** | **333,376.5** | **-67,436.9** |

Эх сурвалж: *Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт авлагын 53.2 хувь буюу 177,318.8 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 46.8 хувь буюу 156,011.4 мянга нь ОНХС-ийн өвс тэжээл, малжуулах төслийн авлага, үлдэгдэл 46.5 мянган төгрөг нь ИТХ-ын авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 93,066.8 | 0.0 | -93,066.8 | 0.0 |
| ИТХ | 0.0 | 46.5 | 46.5 | 0.0 |
| СХС | 209,853.9 | 177,318.8 | -32,535.2 | 53.2 |
| ОНХСан | 97,892.7 | 156,011.4 | 58,118.7 | 46.8 |
| **НИЙТ ДҮН** | **400,813.4** | **333,376.6** | **-67,436.8** | **100.00** |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд ЗДТГ авлага бүрэн барагдаж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 32,535.2 мянган төгрөгөөр буюу 16 хувиар буурсан бол ИТХ-ын ажилчидтай холбогдсон авлага 46.5 мянган төгрөгөөр, ОНХС-ийн өвс тэжээлийн авлага нэмэгдсэнтэй холбогдуулан 58,118.7 мянган төгрөгөөр буюу 59 хувиар нэмэгдсэн байна.

### 3.5.3 Бараа материал

Тайлант оны бараа материал дансны эцсийн үлдэгдэл 407,220.1 мянган төгрөг болж өмнөх оноос 175,088.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бичиг хэргийн материал | 2,747.9 | 2,824.9 | 77.0 |
| Аж ахуйн материал | 4,580.0 | 24,601.3 | 20,021.3 |
| Барилгын засварын материал | 459.0 | 36,566.0 | 36,107.0 |
| Бусад хангамжийн материал | 62,544.8 | 50,415.4 | -12,129.4 |
| Мал амьтад | 35,178.4 | 39,290.0 | 4,111.6 |
| Нөөцийн бараа | 126,621.1 | 253,522.5 | 126,901.4 |
| **Дүн** | **232,131.2** | **407,220.1** | **175,088.9** |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 407,220.1 мянган төгрөг болж 175,088.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЗДТГ-ын аж ахуйн материал дансны үлдэгдэл 20,021.2 мянган төгрөгөөр, барилгын засварын материалын үлдэгдэл 36,107.0 мянган төгрөгөөр, нөөцийн материал дансны үлдэгдэл 83,305.3 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 4,948.4 | 4,948.4 | - | 1.2 |
| ЗДТГ | 106,994.7 | 238,487.8 | 131,493.1 | 58.6 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| ОНХС | 120,188.1 | 163,783.9 | 43,595.8 | 40.2 |
| **НИЙТ ДҮН** | **232,131.2** | **407,220.1** | **175,088.9** | **100.0** |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 653,102.2 мянган төгрөгийн бараа материалаас 418,975.4 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 64,017.7 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, 170,109.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 478,013.3 мянган төгрөгийн бараа материалаас 315,768.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 131,554.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, үлдсэн 30,690.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл*

*/мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 653,102.2 | Хасагдсан | 478,013.3 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 418,975.4 | Худалдсан, зарцуулсан | 315,768.2 |
| Хандиваар | 64,017.7 | шилжүүлсэн | 131,554.3 |
| Шилжүүлэн авсан | 170,109.2 | бусад | 30,690.8 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 3,414,314.4 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 882,539.7 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 2,516,534.7 | 2,958,706.4 | 442,171.7 | 86.7 |
| Барилга байгууламж, орон сууц | 1,896,911.4 | 2,052,733.8 | 155,822.4 | 60.1 |
| Тээврийн хэрэгсэл | 239,034.8 | 336,701.5 | 97,666.7 | 9.9 |
| Машин тоног төхөөрөмж | 209,090.7 | 390,543.4 | 181,452.7 | 11.4 |
| Тавилга эд хогшил | 163,157.8 | 170,387.7 | 7,229.9 | 5.0 |
| Дуусаагүй барилга байгууламж | 7,400.0 | 7,400.0 | 0.0 | 0.2 |
| Номын фонд | 940.0 | 940.0 | 0.0 | 0.0 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 15,240.0 | 455,608.0 | 440,368.0 | 13.3 |
| Программ хангамж | 1,420.0 | 1,420.0 | 0.0 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 13,820.0 | 454,188.0 | 440,368.0 | 13.3 |
| **НИЙТ ДҮН** | **2,531,774.7** | **3,414,314.4** | **882,539.7** | **100.0** |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 99.0 хувийг Засаг даргын тамгын газар, 1.0 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 25,164.3 | 34,391.3 | 9,227.0 | 1.0 |
| ЗДТГ | 2,506,610.5 | 3,379,923.2 | 873,312.7 | 99.0 |
| **НИЙТ ДҮН** | **2,531,774.7** | **3,414,314.5** | **882,539.7** | **100.0** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ
005

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө данс 882,539.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 101,835.8 мянга, хандив тусламжаар 164,185.9 мянга, шилжүүлэн авсан 305,215.8 мянга, бусад 440,368.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (Үүнд: аймгийн ОНӨГ-ын 2024 оны А/176 дугаар албан бичгээр ЗДТГ-т 220,184 мкв газар шилжүүлсэн) үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Харин 129,065.8 мянган төгрөгөөр хасагдсан нь Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 39-р захирамжын дагуу шилжүүлсэн хөрөнгө байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл* /мянган төгрөг/

| | | | |
|---|---|---|---|
| Нэмэгдсэн | **1,011,605.5** | Хасагдсан | **129,065.82** |
| Худалдан авсан | 101,835.8 | Худалдсан | 0 |
| Хандиваар | 164,185.9 | Акталсан | 0.00 |
| Шилжүүлэн авсан | 305,215.8 | Шилжүүлсэн | 129,065.82 |
| бусад | 440,368.0 | Бусад | 0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16,237.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 69,182.1 мянган төгрөг болж 52,944.7 мянган төгрөгөөр *өссөн* байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 16,237.4 | 69,182.1 | 52,944.7 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 0.0 | 1,404.0 | 1,404.0 | 2.0 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - | - | - |
| Байгууллагад төлөх өглөг | 16,133.6 | 67,573.3 | 51,439.7 | 97.7 |
| Хувь хүмүүст өгөх өглөг | 103.8 | 204.8 | 101.0 | 0.3 |
| **Дүн** | 16,237.4 | 69,182.1 | 52,944.7 | 100.0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 69,182.1 мянга болж эхний үлдэгдлээс 52,944.7 мянган төгрөгөөр *өссөнөөс* 4,764.5 мянга нь ЗДТГ-ын өглөг, 48,180.2 мянга нь ОНХС-ийн дуусаагүй ажлын өглөг байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| СХСан | 4.8 | 4.8 | - | 0.0 |
| ЗДТГ | 109.6 | 4,874.1 | 4,764.5 | 7.0 |
| ОНХС | 16,123.0 | 64,303.2 | 48,180.2 | 92.9 |
| ДҮН | 16,237.4 | 69,182.1 | 52,944.7 | 100.0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,419,163.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,613,291.9 мянган төгрөг болж, 1,194,128.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 926,296.7 | 926,296.7 | - | 25.6 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 1,326,406.9 | 2,520,535.4 | 1,194,128.5 | 69.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 166,459.8 | 166,459.8 | - | 4.6 |
| **Дүн** | 2,419,163.4 | 3,613,291.9 | 1,194,128.5 | 100.0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,194,128.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар 10/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 284,127.7 мянга, хүү торгуулийн орлогыг 4,000.0 мянгаар нийт 288,127.7 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугээр тогтоолоор 340,067.4 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого*

*/мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1.Татварын орлого | 624,195.1 | 881,711.1 | 257,516.0 | 141.3 |
| ЦХТА рлого /суутган/ | 192,000.0 | 222,705.0 | 30,705.0 | 116.0 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 2,300.0 | 2,466.1 | 166.1 | 107.2 |
| Бууны татвар | 1,665.0 | 2,160.0 | 495.0 | 129.7 |
| ИОТХ | 54,348.2 | 77,445.8 | 23,097.6 | 142.5 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,000.0 | 1,977.0 | 977.0 | 197.7 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 29,600.0 | 38,640.7 | 9,040.7 | 130.5 |
| Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого | 2,000.0 | 120.0 | (1,880.0) | 6.0 |
| Малд ногдуулах албан татвар | 52,662.7 | 47,055.6 | (5,607.1) | 89.4 |
| Газрын төлбөр | 1,400.0 | 1,516.9 | 116.9 | 108.4 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,600.0 | 2,267.0 | (4,333.0) | 34.3 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 280,119.2 | 484,857.0 | 204,737.8 | 173.1 |
| ТТАМАТөлбөр | 500.0 | 500.0 | - | 100.0 |
| 2.Татварын бус орлого | 5,000.0 | 10,462.9 | 5,462.9 | 910.9 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 4,000.0 | 1,805.0 | (2,195.0) | 45.1 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 0.0 | 8,657.9 | 8,657.9 | 865.8 |
| **Нийт дүн** | 628,195.1 | 892,174.0 | 263,978.9 | 142.0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 141.3 хувь буюу 257,516.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Үүнээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 30,705.0 мянга, ИОТХ 23,097.6 мянга, хадгаламжийн хүүний орлого 9,040.0 мянга, бууны татвар 495.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 977.0 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 204,737.8 мянган төгрөгөөр давуулан биелсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Төсөвт төвлөрөх татварын бус орлогод төлөвлөөгүй орлого болох төсөвт байгууллагын өөрийн орлого 8,657.9 мянган төгрөг илүү төвлөрчээ.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,389,503.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 1,882,754.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж тайлант оны төсвийн гүйцэтгэлийн зардлын дүн 78.79 хувь байна.

### 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Хүрээмарал сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 10/03 дугаар тогтоолоор нийт 2,035,923.4 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугаар тогтоолоор 353,579.6 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

#### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 10/03 дугаар тогтоолоор анх 2,035,923.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугаар тогтоолоор 353,579.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,389,503.0 мянган төгрөг баталжээ.

Нийт зардлын 321,730.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 996,571.8 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, орон нутгийн өөрийн орлого 628,195.1 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлого 49,460.2 мянга, нийт авлагыг 115,093.5 мянга, төсөвт байгууллагын өөрийн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

орлого 1,000.0 мянга, төсвийн урьд оны үлдэгдэл 230,121.3 мянга, ОНХС-ийн өөрийн орлого 47,331.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн болон санхүүгийн дэмжлэгээс авах санхүүжилтээс 1,952,416.7 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 78,974.5 мянга, нийт 2,031,391.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 133,021.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 988,158.5 | 890,665.2 | 97,493.3 | 90.1 | 100,827.3 |
| ИТХ | 162,461.2 | 146,180.2 | 16,281.0 | 90.0 | 16,281.0 |
| Соёлын төв | 113,160.2 | 110,384.9 | 2,775.3 | 97.5 | 2,775.3 |
| Сум хөгжүүлэх сан | 168,521.5 | 150.0 | 168,371.5 | 0.1 | |
| Сургууль | 144,590.3 | 138,063.4 | 6,526.9 | 95.5 | 6,526.8 |
| Цэцэрлэг | 41,986.7 | 39,312.8 | 2,673.9 | 93.6 | 2,673.9 |
| ЭМТ | 79,381.0 | 75,443.4 | 3,937.6 | 95.0 | 3,937.6 |
| ОНХС | 691,243.6 | 482,554.1 | 208,689.5 | 69.8 | - |
| Нийт дүн | 2,389,503.0 | 1,882,754.0 | 506,749.0 | 78.8 | 133,021.9 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,882,754.0 мянган төгрөг буюу 78.79 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 97,493.3 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 16,281.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 208,689.5 мянга, хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 168,371.5 мянга, соёлын төвийн тогтмол зардлыг 2,775.3 мянга, ЕБС-ийн тогтмол зардлыг 6,526.9 мянга, цэцэрлэг 2,673.9 мянга, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 3,937.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 33,505.2 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хөрөнгө 4,914.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 90,175.0 мянган төгрөг нийт 128,594.2 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 5,550.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 4,486.2 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 28,162.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох шилжүүлэгт 7,433.2 мянган төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд 82,965.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 10,822.0 | 117,772.2 | 128,594.2 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | 0.0 | 4,914.0 | 4,914.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,822.0 | 22,683.2 | 33,505.2 |
| Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.0 | 90,175.0 | 90,175.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 10,822.0 | 117,772.2 | 128,594.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 4,483.2 | 4,483.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | 4,550.0 | 5,550.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,822.0 | 18,340.0 | 28,162.0 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | 0.0 | 7,433.2 | 7,433.2 |
| Биет ба биест бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.0 | 82,965.8 | 82,965.8 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 0.0 | 0.0 | 0.0 |

*Эх сурвалж: Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугээр сарын 06-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүрэээмарал сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Л.Сансаргомбо, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Сэрдагва нар зурж байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт батлагдсан төсвийн 2,389,500.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,895.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,726.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш орлогын 14 гүйлгээ, зарлагын 45 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаанд нь мэдээлсэн байна.

### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Хүрээмарал сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэдэвцэвээн гүйцэтгэсэн ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 1 албан шаардлагын шийдвэрийн хэрэгжилт 100 хувь байна.

*Хүснэгт 17 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт* *<br>/мянган төгрөгөөр/*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | 100 |
| Зөвлөмж | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | **1** | **-** | **100** |

## 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 100,302.0 мянган төгрөгөөр баталж 81,685.8 мянган төгрөгийг зарцуулж 18,634.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хүрээмарал сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 106 арга хэмжээ төлөвлөж 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 95.09 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 106 арга хэмжээнд зориулан нийт 2,389,503.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,882,754.0 мянган төгрөгийг зарцуулж 78.8 хувийн биелэлттэй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Хүрээмарал сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | | **4** | | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 7,969.2 мянган төгрөгийн 2 алдаа,зөрчил илэрсэн байна. Үүнээс 5,889.2 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,080.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

*/мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ИТХурал | - | - | | | | | | | | |
| ЗДТГ | 2 | 7,969.2 | 1 | 5,889.2 | | | 1 | 2,080.0 | | |
| ОНХСан | - | - | | | | | | | | |
| СХС | - | - | | | | | | | | |
| СТА зөрчлийн дүн | 2 | 7,969.2 | 1 | 5,889.2 | - | - | 1 | 2,080.0 | - | - |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн*

*Хүснэгт №19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын Тамгын газар | | 2,080.00 | | | |
| 1 | Тайлант онд өглөгөөр тусгаагүй, 2021 онд хэвлэгдсэн өрхийн дэвтрийн үнэ болох 2,080.0 мянган төгрөгийг Дурсамж принт ХХК-руу шилжүүлсэн байна. | 2,080.00 | Албан шаардлага | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | С.Нархүү, Б.Мэндбаяр |
| | **Нийт дүн** | **2,080.00** | | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,015.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 14,015.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

### 5.1 Зөвлөмж

Тайлант онд үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,880.0 мянга, малд ногдуулах албан татвар 5,607.1 мянга, хог хаягдлын хураамж 4,333.0 мянга, хүү торгуулийн орлого 2,195.0 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө тус тус тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана”, 5.1.1 дэх “Жинхэнэ хэрэгжилтийн”, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

(татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлийн үндэслэлтэй төлөвлөж зарцуулах зөвлөмж хүргүүлэв.

## 5.2 Албан шаардлага

Сумын ИТХ-аар төсөв батлахдаа Хүрээмарал сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж байгаа боловч Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй.

Энэ нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.", 54.5.4 дэх "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга/хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Цаашид ТТЗ-ын санхүүгийн тайланг ирүүлэхдээ "Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5"-д заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,880.0 мянга, малд ногдуулах албан татвар 5,607.1 мянга, хог хаягдлын хураамж 4,333.0 мянга, хүү торгуулийн орлого 2,195.0 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө тус тус тасарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1, 5.1.1, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. | 1 | 14,015.0 | | | | | 1 | 14,015.0 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сумын ИТХ-аар төсөв батлахдаа Хүрээмарал сумын төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталж байгаа боловч Хүрээмарал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр тайланг ирүүлээгүй. | 1 | | | | 1 | - | | |
| **Дүн** | **1** | 14,015.0 | | | **1** | **-** | **1** | **14,015.0** |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------оОо-----------

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ